



Улсын хилийн онол, түүх.

*"Монгол Улсын хил хамгаалалтын
тогтнолоог боловсруулж бэлтгэж
онол-аргын зүйл агуулсан"*

/ХЦДС-ийн багш нарын Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлээс товчлон нийтлэв/

*БХИС-ийн ХЦДС-ийн ЭШТ-ийн тэргүүлэх
ажигтан, ИЦШУ-ны доктор
(PhD) профессор, дэслэгч генерал Ш.Арвай*

МОНГОЛ УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ХОГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Нөхдөө!

Монгол Улс тусгаар улсаа сэргээж, оршин тогтнолоо бататгасан XX зууныг үдэж шинэ зууны хаалгаар зориг бадрангуй орж байна. Энэ үе бол хүн төрөлхтний 2000 жилийн хөгжлийн шувтрага гурав дахь мянганы магнай жил юм. Хэзээ ч давтагдашгүй, түүхэн энэ үед зохиогдож байгаа ач холбогдлын хувьд энэ зэрэгцэхийн аргагүй өндөр хэмжээний бага хуралд оролцож бодол саналаа хэлэх завшаан тохиосонд сэтгэл өндөр байна. Энд Монгол улсын хил, түүний хамгаалалтын хөгжилд шийдвэрлэх нөлөөтэй байх жамтай офицер, боловсон хүчний уурхай болсон ХЦДС, түүний дэргэдэх ЭШТ, Хил судлал зэрэг эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын эрдэмтэн, профессор, багш, судлаачид оролцож онол практикийн бага хурлаар чухлын чухал асуудлыг авч хэлэлцэж байгаа тохиолдлоор бус ерөөлөөр учирсан үйл явдал гэж үзэж байна.

Энэ бага хуралд оролцож байгаа та бүхний сонорт хүргэх илтгэлээ, хилийн цэргийн албанд 43 жил зүтгэхдээ ажиглаж, судалж шинжилсэн онол практикийн шинжтэй дүгнэлт саналаа чөлөөтэй илэрхийлэх хэлбэрээр толилуулъя.

1.Хил хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйлсийн тойм

Өнгөрч байгаа зуун нь дэлхийг хуваах, дахин хуваах их

гүрнүүдийн сонирхол өрсөлдсөн, түрэмгийлэлээр сонирхлоо хангах гэсэн ширүүн тэмцлийн зуун байлаа.

Гэвч монголчуудын хувьд гайхамшигтай үр өгөөжтэй зуунд тооцогдоно гэж үзэж байна. Одоо дэлхийд 6 тэрбум хүн оршин амьдардаг 230 том, жижиг улс байна. Үүнээс 184 улс нь НҮБ-ын гишүүн юм. Дэлхийн хүн амын 0.004 хувийг эзэлдэг 2.3 сая хүнтэй, тэгсэн мөртөө дэлхийн хуурай газрын бүхэл бүтэн 1 хувийг эзэлсэн арвин шим бүхий баян тансаг газар нутагтай Монгол улс НҮБ-ын гишүүн болох хувь тавилан заяана гэдэг бол монголчуудын гайхамшиг гэхээс өөр үнэлэлт олдохгүй бизээ. Дэлхийд хэдэн арван сая хүнтэй улс байвч бүгдээр НҮБ-д багтаж чадаагүй байна. Монголыг 221 жил, Хятадыг 268 жил эрхшээлдээ байлгасан Манж гүрэн дэлхийд дурсагдах нэргүй болж уусан устсаныг та бид харж байна. Энэ бол ердийн л нэг баримт.

Монгол Улсыг улс гүрний хэмжээнд монголчуудын дунд шомбойн үлдэхэд юу нөлөөлөв. Түүний тусгаар тогтнолыг гүйцэлдүүлэгч тулгуур хүчин зүйл болох улсын хилийг тогтоож, хамгаалсан явдал юм. Энэ нь хэн нэгэн хүний гавьяа хараахан бишээ. Монгол Улсын одоогийн 8162 км хилийн шугамаар зааглагдсан нутагт амьдрах хүслэн монголчуудын амин чухал эрх ашиг байсан учраас бүгд ийм бие даасан улс байхыг эрхэмлэн нэгэн дуугаар гар өргөн баталсан. Улсын зиндаанд оршин тогтнох боломжийг дэлхийн хоёрдугаар дайны явцад дэлхийд шийдвэрлэх үүрэг рольтой оролцсон гурван гүрний тэргүүний бага хурлын шийдвэрээр нотолсон юм.

Монгол Улсын тусгаар тогтнолыг тэр үед байсан хязгаараар нь хил болгон зааглаж үлдээхийг Японы түрэмгийлэгчдийн эсрэг дайнд ЗХУ, Хятад улсын цэрэг оролцон шийдвэрлэх улстөрийн болзол болгон тавьж энэхүү дайны явц дунд эцсийн шийдвэрийг гаргаж хөрш хоёр гүрэн хүлээн зөвшөөрсөн. Эцэст нь хилээ тэр л эрх хэмжээний хязгаарт л багтаан гүйцэтгэж баталгаажуулсныг та бүхэн мэдэж байгаа. Эндээс улсын хил, түүний хамгаалалт нь улсын оршин тогтнолын амин сүнс болох нь онол, практикийн нотолгоо шаардагдахгүй илт харагдаж байна. Яагаад гэвэл аливаа улсын ард түмнээс сонгогдсон төр нь чухамдаа хилээр хязгаарлагдсан тэрхүү газар нутгийн хэмжээнд л улс иргэдийнхээ эрх ашгийг хангах, хамгаалах, газар нутаг, түүний баялгийг захиран зарцуулах эрх зүйн үндэстэй болдогт асуудлын мөн чанар оршиж байна. тэхдээ Монгол улс хөгжлийнхөө хувьд хүнээр ярьвал өсөлт бойжилтын шатанд байгаа ба эрийн цээнд хараахан хүрч улс орноо эрчимтэй хөгжүүлэх шатанд шилжээгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй бизээ. Энэ зуунд эзлэх Монгол

улсын хөгжлийн нэг онцлог нь энэ юм.

Монгол улс эх орондоо хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулах шинэ Үндсэн хуультай шинэ зууны босгыг алхаж байна. Энэ зуун нь хүний ертөнц асуудлыг хүчээр бус, аль болохоор харилцан ойлголцон шийдвэрлэх зарчимд тулгуурласан нэгэн ерөтнцийнхөө төлөө нийтээр тэгш эрхтэй үүрэг хариуцлага хүлээх глобалчлал буюу даяарчлах, дэлхийчлэх уур амьсгал давамгайлсан шинжтэй байх төлөв харагдаж байна.

Энэ зуунд Монгол Улсын оршин тогтнолд улсын хил, түүний хамгаалалт шийдвэрлэх нөлөөтэй, харин хилийн цэрэг батлан хамгаалах салбарт тэргүүлэх рольтой байна гэдэг үзэл баримтлалд миний бие хатуу итгэл үнэмшилтэй байгааг энд зориуд тэмдэглэе. Энэ бол судалгааны ажлын гол үр дүн юм. Үүнийг би дараахь гурван хүчин зүйл нөхцөл байдалтай холбон илэрхийлье. Үүнд:

1.МОНГОЛ УЛСЫН ТОГТООГДОЖ ТЭМДЭГЛЭГДСЭН ХИЛИЙГ ӨӨРЧЛӨХГҮЙ ХЭВИЙН ХЭМЖЭЭНД БАЙЛГАЖ, ХИЛ ДЭЭР ГАРЧ БОЛЗОШГҮЙ ЯНЗ БҮРИЙН ХЭЛБЭРИЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ГАРСАН ТОХИОЛДОЛД ТЭДГЭЭРИЙГ ХИЛИЙН ЦЭРЭГ НЬ МӨРГӨЛДӨӨН, ДАЙНЫ ШАЛТАГТ ХҮРГЭХГҮЙ БАЙХ ТҮВШИНД ШИЙДВЭРЛЭХ ЧАДВАРТАЙ БАЙСНААР МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМТЭЙ ХӨГЖЛИЙН ЭНХ ТАЙВАН АЮУЛГҮЙ ТААТАЙ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ НАЙДВАРТАЙ БҮРДҮҮЛЭХ ХҮЧИН ЗҮЙЛ БИЙ БОЛНО ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА.

Монгол Улс хөгжлийн хэмжээгээр наанадаж улс гүрний хувьд хоёр хөрш гүрний түвшинд хүрэх, ойртох, ард түмнийхээ ахуй соёлын хэмжээг, эдгээр гүрнүүдийн зиндаа түвшинд хүргэх нь Монгол Улсын эрхэм зорилго байх болно. Энэ бол зүй тогтлын шинжтэй бодит шаардлага мөн. Хэдэн мянган жилийн тэртээ Монгол гүрэн хөршөөсөө хөгжлийн түвшингээр хоцрогдохооргүй хэмжээнд байж, төмөр эдлэл, зэр зэвсгээ үйлдвэрлэж байсан бол одоо улс орны хөгжил, ард түмний бодит орлогын түвшин хөрш улсуудаас хол хоцорч явааг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Хөгжлийн энэ асуудал улс орны маань тусгаар тогтнол орших, эс оршиход түүнчлэн зарим улс гүрний геолустрений бодлогод янз бүрээр нөлөөлнө. Үүнээс гарах зам бол манай улс өөрийн орны эдийн засаг, нийгмийн бололцоо, чадавхийг дээд зэргээр ашиглаж, үсрэнгүй хөгжлийг хангах арга зам эрэхээс өөр аргагүй байдалд хүргэнэ. Тэр нь юуны урьд улсын хилийн халдашгүй дархан байдлыг баталгаатай хангах чадвараас их шалтгаалах зүй тогтолтой болох нь харагдаж байна.

2.МОНГОЛ УЛСЫН ХИЛ ХАМГААЛАХ ҮНДСЭН

БАЙГУУЛЛАГА НЬ ХИЛИЙН ЦЭРГЭЭС ӨӨР ЯМАР Ч СУБЬЕКТ БАЙХ БОЛОМЖГҮЙ ГЭСЭН ЗҮЙ ТОГТЛЫН ШИНЖТЭЙ ХҮЧИН ЗҮЙЛ ҮЙЛЧИЛЖ БАЙНА.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байршил одоогийн байдлаар төвөөсөө хязгаарлуугаа хандсан чиглэлтэй явагдаж байна. Энэ нь тийм ч оновчтой тогтолцоо бишээ. Энэ үйл ажиллагаа цаашид энэ хэвээр үргэлжилвэл улс орны тусгаар тогтнолд туйлын ноцтой нөлөөлнө. Учир нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн гольдролыг дагаад хязгаар нутагт эртнээс нааш иргэд сийрэг суурьшилтай байсан, байгаа нь амьдралын бодит шаардлагад хөтлөгдөн хязгаараас хөгжил давуутай төвийн хэсэг рүүгээ тэмүүлэн нүүдэллэнэ. Энэ үзэгдлийг дагаад хязгаар эзгүйдэж, газар нутаг байгалийн асар үнэтэй баялаг бусдын сонирхол татсан объект болон хувирна. Үүнээс гарах нэг арга бол XXI зууны Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил хязгаар нутаг, ялангуяа хил орчмын газарт илүүтэй байх олон улсын хөгжлийн зүй тогтолт хандлагад нийцэж хэрэгжих ёстой болно. Энэ нөхцөлд хил орчмын газар нутагт хүн амын суурьшил идэхижиж, дэд бүтэц хөгжиж, хот суурин бий болж, ард иргэд, хилчдийн нийгмийн баталгаа дээшилнэ. Эх орны төвийн бүсийн баялаг алсад ашиглах нөөцийн байдалд шилжинэ. Энэ нөхцөлд ард иргэд төврүүгээ биш хязгааруугаа нүүдэллэх, суурьших нөхцөл бүрдэнэ. Гэвч энэ ажиллагаа хэрэгжиж үр дүнгээ өгөх хүртэл их хугацаа, хүч хөрөнгө шаардлагдана. Ийм учраас эзгүй алслагдсан зайд улс орон, ард түмнийхээ ашиг сонирхлыг хангах онцгой хүнд нөхцөлд ажиллах, тангараг өргөсөн цэрэгжүүлсэн тусгай хүчин байхаас өөр аргагүй. Энэ бол мэргэжсэн, шалгарсан, хатуужсан хилийн цэргээс өөр хэн ч биш гэдэг нь амьдралаас харагдаж байна.

**3.МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС БАРИМТАЛДАГ ЦЭРГИЙН
НОМЛОЛД ӨНГӨРСӨН ЗУУНД ХИЛИЙН ЦЭРЭГ СЭРЭМЖЛЭХ
АГУУЛГАТАЙ ТУСЛАХ ЧАНАРТАЙ ҮҮРЭГТЭЙ ЯВЖ ИРСЭН БОЛ
ХАРИН ШИНЭ ЗУУНД МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАЛТАД
ШИЙДВЭРЛЭХ ҮҮРЭГ РОЛЬТОЙ ОРОЛЦОХ ЗҮЙ ТОГТОЛ ҮЙЛЧЛЭХ
БОЛНО.** Өнгөрсөн зуунд цэргийн түрэмгийллийн магадлал илүүтэй байсан болохоор Монгол Улсын цэргийн номлолын агуулга нь хилийн цэргийн багахан хүчээр хязгаараа харж хамгаалах, түрэмгийллийн аюул тохиолдсон нөхцөлд зэвсэгт хүчний үндсэн хүчээр цөмөрсөн дайсныг цохиж, хүчин мөхөсдсөн нөхцөлд Зөвлөлтийн улаан армийн тусламжтайгаар халдлагыг няцаан устгаж улсын хилийг урьдын байсан хэмжээнд сэргээх чиглэлтэй байжээ.

Энх тайван, итгэлцэл ноёлох хандлагатай байж болох шинэ

зуунд Монгол Улсын цэргийн номлолын үндэс нь юуны урьд тогтоогдсон хилийг хэвийн хэмжээнд байлгаж, хилийн зөрчлийг зэвсэгт мөргөлдөөн халдлагад шилжин өргөжих шалтаг бий болгохгүй байх түвшинд хилээ хамгаалах, халдаг түрэмгийллийн шинж үйлдэл гарсан тохиолдолд хил халхлалтын цомхон зэвсэгт хүчин, шаардлагатай үед НҮБ-ын энхийг сахиулах хүчний оролцоотойгоор шийдвэрлэх чиглэлтэй байх шинж харагдаж байгаа юм.

Энд би хил хамгаалалтад нөхцөлдөж болох олон хүчин зүйлийг нөлөөлөөс тойм хэсгийг маш товчоор дурдлаа.

2.Улсын хил, түүний хамгаалалтын хөгжлийн чиг хандлага

Монгол Улсын хил, түүний хамгаалалт нь ирэх зуунд ямар үр дүнтэй хэрэгжих нь **нэгдүгээрт** улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үндсэн үүрэгтэй хил хамгаалах байгууллагыг эрх үүргээ хэрэгжүүлэх найдвартай хэрэгсэл хөрөнгийн бололцоо нөхцөлөөр төрөөс дүүрэн тасралтгүй хангах объектив тал, **хоёрдугаарт** олгогдсон хүч хэрэгсэл, хөрөнгийг хилийн цэрэг хамгийн дээд зэргийн үр өгөөжтэй ашиглах чадвартай байх субъектив хүчин зүйлээс шалтгаална. Тэдгээр хүчин зүйлийг зөв тодорхойлж, хэрэгжүүлэхэд хил хамгаалалтын хөгжлийн хэтийн чиг хандлагыг ерөнхий боловч тоймлон төлөвлөх нь ашигтай гэж үзэж байна. Би энэ чиглэлийг дараахь зүйлүүдэд багтаан илэрхийлье. Үүнд:

Нэг. Монгол Улсын хил түүний хамгаалалт нь олон улсын нийтээр зөвшөөрсөн хууль, хэм хэмжээний дагуу хөгжих чиг хандлагатай байх болно. Энэ нь нэг агуулгатай хоёр чиглэлтэй багц асуудал юм. Нэг нь улсын зөвшөөрөгдсөн хилийн боомтоор зорчигчид, бараа таваар, тээврийн хэрэгслийг зохих журмаар нэвтрүүлэх, нөгөө нь гарцгүй хилийн бусад хэсгийг зөрчилгүй байлгах, хамгаалах асуудал юм. Хил тогтоох, хамгаалах талаар монголчууд олон мянган жилээр дэлхийн харилцаанд оруулсан арвин туршлагатай улсын нэгээ. Орчин үед манай улс дэлхийн олон зуун улсын хил хамгаалахад нэвтэрсэн техник, технологи туршлага авахгүй ашиглахгүй байхын аргагүй. Хил хамгаалалт ялангуяа шалган нэвтрүүлэх чиглэлээр даяарчлах, дэлхийчлэх чиг хандлага эрчимтэй явагдана. Монгол Улсын хил нь дэлхий дээрх олон улсын хилийн салшгүй хэсэг, түүний шалган нэвтрүүлэх боомтууд дэлхийн нийтлэг сүлжээнд орж НҮБ-аас зохицогдсон ерөнхий зарчимд үндэслэгдэн бодлого үйл ажиллагаа нь явагдана. Энэ утгаар авч үзвэл аливаа улсын хил, түүний хамгаалалт тухайн улсын нийгмийн байгуулалд үл

хамаарагдан, харин улсын үндэсний язгуур эрх ашиг, ард түмний мөнхийн сонирхлыг дээдлэх олон улсын эрх, зүй тогтолд зохицогдох журмаар хөгжих хандлагатай болж байна.

Хоёр. Улсын хил, түүний хамгаалалт төрийн тусгай бодлогоор зохицуулагдаж, эрсдэл тасалдалгүй үндэсний уламжлалд суурилан эрчимтэй хөгжлийн шинжтэй явагдана.

Төрөөс баримтлах хилийн тухай бодлого гэдэг бол хилийн асуудлын хүрээнд төр өөрийнхөө зорилт чиг үүргийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа юм. Одоо хэр энэ асуудлыг төр хавсрага маягийн асуудалд тооцож ирсэн. Ийм учраас хил хамгаалалт тасалдаж, зарим үед улс оронд учрах аюулын уршигтай шалтаг шалтгаан болж, эх орныг хүнд байдалд оруулах явдал нэг биш удаа гарч байсныг энд нурших явдалгүй билээ. Улсын хэмжээнд тогтоогдоогүй гэж тэр үед байсан монгол, баргын хилийг Японы түрэмгийлэгчид шалтаг болгон газар булаалдан Халх голын дайн дэгдээсэн боловч хил тогтоогдсоноор энэ асуудал шийдэгдсэн. Социализмын зорилтыг хэрэгжүүлэх нэг далбаанд орсон гэж үзээд Монгол Улс хилийн цэргээ татан буулгаж, хилээ албан ёсоор тогтоох үед газар нутгаа алдлаа гэж зэмлэлд багагүй өртсөн. Энэ хоёр баримтыг энд дурдахад дээрх алдааг нотлох хангалттай баримт болно. Хил түүний хамгаалалтын талаар баримтлах бодлогтой байснаар ямар нийгэм байгуулж байгаагаас төдийлөн хамааралгүй энэ асуудал мөнхөд хөгжиж боловсронгуй болж байх үндэс тавигдана. Төрөөс баримтлах хилийн тусгай бодлоготой байснаар наанадаж дөрвөн асуудал шийдэгдэх эрх зүйн үндэс тавигдана.

1. Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах нь улсын үндэсний язгуур эрх ашиг, Монголын ард түмний мөнхийн ашиг сонирхол, Монгол улсын оршин тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, эрх зүйт төрийн амин чухал нэн тэргүүнд анхаарах хэсэг гэдгийг улс төрийн хувьд хүлээн зөвшөөрч баталгаажуулах

2. Эдийн засгийн хувьд улс төрийн энэ чиг шугамыг тулгуур зарчим болгон улсын хил, түүний хамгаалалтыг ялангуяа зэвсэглэл, техник, санхүүгээр бэхжүүлэхэд төр өөрөө улсын эдийн засаг оюуны чадавхи боломжийг нэн тэргүүнд энэ хэсэгт анхааран чиглүүлэх эрх зүйн үндэс бий болж хэрэгжинэ.

3. Цэргийн салбарт Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын магнайд нь монголын хилийн цэрэг, түүний материал техникийн баазыг бэхжүүлэх чиг шугамыг тавьж хэрэгжүүлэх зарчим бүрдэнэ.

4. Улсын хил, түүний хамгаалалт, хилийн цэргийн алба-

онцгой анхаарлын төвд байж энэ үйл хэргийг ерөнхийлөгч зэвсэгт хүчний командлагч, ерөнхий сайд шууд удирдан зохион байгуулахаар энэ баримт бичигт тусгалаа олсон байх шаардлагатай гэж үзэж байна.

Ингэж шийдвэрлэснээр тогтсон аливаа хэв заншил журам, ямар нэгэн эрх ашиг эвдэгдэж байгаа бус урьд ч байсан одоо ч байгаа, цаашид ч байх ёстой тодорхой удирдлагын нэг л хэлбэр бодитой үйлчлэх юм. Ийм тогтолцоо буй болсон нөхцөлд л улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах бүх механизм тасалдалгүй ажиллах бололцоотой болно. Энэ нь хэнээс ч хараат бус байдлаар хөгжлийнхээ чиг хандлагыг сонгон авч байгаа Монгол Улсын хөгжлийнх нь нэг өвөрмөц шинж байдалтай холбогдож байгаа юм.

Гурав. Монгол Улсын хил, түүний хамгаалалт, хилийн цэрэг, түүний материаллаг баазын бэхжилт, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний ерөнхий хөтөлбөрөөр хэрэгжинэ. Хөтөлбөр нь төрөөс хилийн тухай баримтлах бодлогын салшгүй хэсэг байх болно. Хөтөлбөртэй байж түүнийг ашигласнаар улсын хил хамгаалалтын халдашгүй дархан байдал чиглэсэн зорилготой, алсыг харсан чиг хандлагатай, боловсон хүчин, удирдлагын аливаа субъектын халагдалт, солигдолтод өртөлгүй эрчимтэй хангагдах үндэс тавигдана. Харин төр засаг, захиргааны ээлжит халаа сэлгээний үед уг хөтөлбөрөөс хийх хугацаа, хэрэгцээ болсон арга хэмжээг 5-10 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр салган авч эрхэм зорилгын хэлбэрт оруулан биелүүлэх боломжтой. Өндөр түвшингийн нарийн мэргэжлийн судлаачид энэ хөтөлбөрийг бэлтгэх тодотгох шаардлагатай.

Монгол Улсын хилийг өмнөд хил дээр 5 жил, умард хэсэгт 20 жил тутам хоёр улсын Засгийн Газрын хамтарсан шалгалтаар тодотгож байна гэж заасан олон улсын эрхийн акт одоо ч бидний гар дээр байна. XXI зуунд энэ ажил хэдэн удаа явагдах нь тодорхой бөгөөд гүйцэтгэх арга хэмжээ чиглэл илэрхий байна. Эдгээрийг урьдчилан төлөвлөхөд ямар ч бэрхшээл байхгүй. Хилийн асуудалд хамаарах бусад бүх асуудлыг энд төлөвлөх боломжтой. Ингэж хөтөлбөр төлөвлөгөөтэй ажилласнаар улсын хил, түүний хамгаалалтын хөгжлийн тасалдал арилж уламжлалаа хадгалан хөгжих бүрэн боломж бий болно.

Дөрөв. Монгол Улсын хил хамгаалалт, хилчдийн үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэлтэй, тэр нь хөтлөх тэргүүлэх чиглэлтэй явагдана. Эрдэм шинжилгээний ажил шоовдорлогдох бус харин бүх хилчний амин чухал хэрэгцээ болно. Улсын хилийн тухай онол нь стратеги, оперативийн урлаг, тактикийн түвшинд жинхэнэ утгаараа орж хэрэгжинэ. Өндөр түвшингийн, нарийн

Улсын хилийн тухай онол нь стратеги, оперативийн урлаг, тактикийн түвшинд жинхэнэ утгаараа орж хэрэгжинэ. Өндөр түвшингийн, нарийн мэргэжлийн судлаачдаас бүрдсэн эрдэм шинжилгээний байгууллага, ялангуяа офицер боловсон хүчин бэлтгэдэг сургуулийн зиндаа, ач холбогдол, арга ажиллагаа цоо шинэ шатанд тавигдана. Сургууль эрдэм шинжилгээний байгууллага нь хилийн цэргийн үйл ажиллагаа, хил хамгаалалтад хөтлөх, дагуулах үндсэн хүчний шинжтэй болж байраа эзэлнэ. Товчоор хэлэхэд хилийн цэрэгт энэ талаар хувьсгалын шинжтэй шинэчлэл зайлшгүй гарах ёстой. Энэ чанараар улсын хилийн хамгаалалт зэвсэгт тэмцэл, тодруулбал хил хамгаалалтын бодит хууль зүй тогтол, үзэгдэл зарчмаараа баяжиж хөгжих болно.

Тав. Хил хамгаалалтын урлаг шинэ шинэ үзэгдэл үр дүнгээр баяжих боловч улсын хилийн орон зайн хөгжил зохицуулалт, анхаарал онцгой татдаг бүс нутгийн хамгаалалт, бэлтгэл хүчний бэлэн байдал, удирдлагад илүү өндөр ач холбогдол өгөх зарчмаар хөгжино гэж үзэх нь зүйтэй бизээ.

Энэ нь ирэх зууны дэлхийн чиг хандлага ерөнхийдөө зөөлөн уур амьсгалтай байх боловч Монгол Улсын хилийн цэрэг-улс төрийн байдалд ээдрээтэй цаг үе тохиолдохыг үгүйсгэхгүй. Энэ нь бас нөхцөл байдал амар хялбар байна гэж төсөөлөх нь хилчдийн хувьд байж боломгүй явдал гэж үзэх үндэс байгаатай нөхцөлдөж холбогдож байгаа юм. Урьдах зуунд улсын хил дээр гарч байсан хилийн зөрчил, будлиан, хорлон сүйтгэх ажиллагаа, халдлага, түрэмгийлэл гэсэн таван үйлдлээс зэвсэгт мөргөлдөөн түрэмгийлэлд хүргэлгүйгээр хилийн асуудлыг шийдвэрлэх бодит шаардлагат нийцүүлэн шинэ зуунд хил хамгаалалтыг бэлтгэж явуулах боломж байгааг энд би онцлон дурдахыг хүсэж байгаа юм. Харин хилийн зөрчил, гарах магадлал их байгаа төдийгүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээг идэвхижүүлэхгүй бол хилийн будлиан, зарим тохиолдолд зэвсэгт халдлагад өртөх байдал гарч болохыг үгүйсгэх аргагүй. Тайван цагт хилийн зөрчлийн агуулга нь хулгайн аргаар өндөр ашиг орлого олж авах гэсэн үйлдлээр илэрдэг. Ихэнх нь ахуйн шинжтэй. Гэвч ахуйн зорилго агуулгатай зөрчлийн үйлдэл нь хэн нэгнээс ялангуяа хилчдийн хараа хяналтаас нууц далд явагдах шаардлагатай болдог. Эндээс ургаад янз бүрийн тохиолдолд хил дээр гэмгүй иргэд хилчдийн цус урсаж амь нас хохирч, ахуйн зөрчил гинжин урвалаар улс төрийн шинж агуулгатай болж хувирах нь цөөнгүй. Тэр нь цаанаа олон хүчин зүйлийн нөлөөлөл, нөхцөл байдалтай холбогддог. Энэ бүхэн аяндаа Монгол улсын хил, түүний орчмын нутаг дэвсгэр түүн дээр оршин суугчдын эрх ашгийг

хамгаалах буюу бүхэлд нь хилийн орон зайг улсын хил хамгаалалтын үндсэн объект гэж үзэх шинэ үзэгдлийг бий болгож байна. Судалгаанаас харахад Дорноговь, Дорнод, Ховд, Увсын чиглэл урьдын адил онцгой анхаарал татсаар байна. Ер нь хилийн цэрэг аюул учирч болох хэсгийн хамгаалалтад илүү анхаарч хүч хэрэгслээ тэнд төвлөрүүлэн үр дүнтэй ашиглах, шаардлагатай нөхцөл байдалд зохицуулан нэг хэсгээс нөгөө чиглэлд бэлтгэл хүчний хэлбэрээр хүч хэрэгслийг шилжүүлэн бүлэглэх чиг хандлагатайгаар хил хамгаалалтын урлаг хөгжих байх гэж бодож байна.

Зургаа. Монгол Улсын хил хамгаалалтын арга үргэлж боловсронгуй болж байх ба энэ нь хамгаалалтад шинэ зэвсэг, техник хэрэгсэл эрчимтэй нэвтрэх бодит шаардлагатай холбоотойгоор хөгжинө. Энэ асуудлыг манай улс ЗХУ-ын тусламжтайгаар боломжийн хэмжээнд шийдвэрлэж ирсэн. Одоо зэвсэглэл техникт паркийн шинэчлэл хийх шатанд хүрээд байна. Гэвч энэ асуудлыг шийдэхгүйгээр хилийн цэрэг байх түвшиндээ байж чадахгүй. Тэр хэмжээгээр Монгол Улсын тусгаар тогтнолд эсрэгээр нөлөөлнө. Хилийн цэргийг орчин үеийн зэвсэглэл, техник шинэ технологиор хангах нь тийм чухал асуудал уу? Тиймээ. Үүнээс тойрох ямар ч арга байхгүй. Энэ юунаас урган гарч байна вэ? гэвэл **нэгдүгээрт**, Монгол Улсыг олон улсын тавцанд өндөр хөгжилтэй орны сонирхол татах объект болгох хэмжээнд хөгжүүлье гэвэл юу юунаас урьд улсын хил нэвтэрдэг боомтын ажиллагаанд хамгийн орчин үеийн техник хэрэгсэл технологи нэвтрүүлж, зорчигчид тээврийн хэрэгсэл, ачаа барааны урсгалын үйлчилгээг шуурхай хөнгөлөлттэй, аль ч орноос дутахааргүй түвшинд хүргэхээс өөр арга зам байхгүй. **Хоёрдугаарт** Хөршүүд маань үйлдвэр-хөдөө аж ахуй зонхилсон чиглэлээр эрчимтэй хөгжиж байна. Хүн тухайн нийгмийн бүтээгдэхүүн юм болохоор эдгээр улсаас улсын хилийн зөрчил үйлдэгч этгээдүүд нийгмийн хөгжлийн дагуу хамгийн орчин үеийн онгоц, машин, зэвсэг, технологи арга заль үйлдэлдээ ашиглана. Тэдгээрийн эдэлж хэрэглэж байгаа тэмцлийн хэрэгслээс доогуургүй зэвсэг хэрэгсэл, арга ажиллагаа эзэмшсэн нөхцөлд л монголын хилчид үүргээ найдвартай биелүүлэх боломж, буй болно. Бид хилийн цэргийн зэвсэглэл, техникжилтийг аажимдаа бий болгох эх орны үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнээс гадна дэлхийн нааштай хандсан улс бүхнээс олж авах арга механизм бий болгохоос өөр аргагүй. Үүнд бүс нутгийн улс гүрэн, хөрш улсуудын тусламж дэмжлэг авах боломж байхыг мартах учиргүй. Монгол Улсын хил хамгаалалт зөвхөн Монгол Улсын эрх ашиг бус бас дэлхийн бүс нутгийн улсууд ялангуяа хөрш гүрнүүдийн

хэдхэн жилд Монголын хилчид хөрш улсуудаас гадна АНУ, Япон, Энэтхэг, Турк, Египет, Герман, Англи зэрэг нөлөө бүхий улстай гадаад харилцаагаа хөгжүүлж байгааг дэмжих ёстой. Энэ бол шинэ хандлага гэж үзэж байна. Монгол Улс, ОХУ-ын Ерөнхийлөгчийн гарын үсэг зурсан 2000 оны Улаанбаатарын тунхаглалд хоёр улсын хилийг тодотгон шалгаж байгааг өндөр үнэлж, хил дээрх дэг журмын сахилтыг сахиулахад хоёр улсын хууль хамгаалах, хилийн болон гаалийн байгууллага, тусгай албадын уялдан зохицуулсан ажиллагааг хамтран явуулаж байхаар тусгагдсан нь өндөр ач холбогдолтой юм. Үүнийг эрх зүйн орчноос практикийн орон зайд чадварлаг шилжүүлэх зорилт манай холбогдох байгууллага, хилчдийн өмнө тулгарч байна. Үүнийг зохицуулахад Ерөнхийлөгч, Зэвсэгт Хүчний Ерөнхий командлагч, Ерөнхий сайд нар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Түүний хэлбэр нь Засгийн газрын онцгой комисс байж болох юм.

Долоо. Монгол улсын хил хамгаалалтын тогтолцоо, хилийн цэргийн байгуулалт нь шинэ шинэ үзэгдэл үйл явдлаар баяжин хөгжинө. Энэ талаар үндсэн илтгэл болон хавсралт илтгэлүүдэд мэргэжлийн чиглэлээр дурдагдах учраас давхардуулж бичсэнгүй.

3. Дүгнэлт санал

Монгол Улс хөгжлийнхээ шинэ шатанд шилжин орлоо. Түүний хөгжлийн эрчимтэй байх эсэх нь Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал хэрхэн хангагдсанаас шууд шалтгаална. Энэ эрхэм зорилго ажил хэрэг болоход Монгол Улсын хилийн цэргийн алба-байлдааны бэлэн байдал шийдвэрлэх нөлөө үзүүлнэ. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын магнайд нь байж тэргүүн шугамд үүрэг гүйцэтгэж байгаа хилийн цэрэг, хил хамгаалалтын урлаг чанараас чанарт шилжин хөгжиж бэхжих нь зайлшгүй бодит шаардлага мөн. Энэ бол шинэ зуунд Монгол Улсын батлан хамгаалах үйлсийн хэрэгжилтийн өвөрмөц нэгэн онцлог гэж үзэж байна.

Монгол Улсын хил хамгаалалтад нөлөөлөх объектив ба субъектив хүчин зүйлийг харгалзан үзэж оновчтой ашиглан төрөөс энэ талаар баримтлах тусгай бодлого, хөтөлбөрөөр түүнийг зохицуулан шийдвэрлэх нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын амин чухал хэсгийн нэг нь байх болно. Дэлхий, бүс нутаг, хөрш улстай найрамдалтай оршин амьдрах уур амьсгал бий болсон учраас улсын хил хамгаалалт шаардлагагүй мэтээр үздэг үзэл бодлын төөрөгдөл, зарим эрдэмтдийн бодол санаатай санал нийлэхгүй байдгийг энд тэмдэглэе. Харин сайн

хөрштэй, дэлхий бүс нутгийн улсуудтай найрамдалт өргөн харьцаатай байя гэвэл улсынхаа хил, түүний орчмын газар нутгийг найдвартай манаж, улс ард түмнийхээ язгуур эрх ашгийг тууштай хамгаалах нь хэнээс ч хамаарахгүй зүй тогтлын шинжтэй үйлдэл гэдгийг онцлон үзэж, хэзээ ч мартахгүй байх нь туйлын ач холбогдолтой гэж үзэж байна.

Энэ байр сууринаас хил хамгаалалтын зардлыг авч үзвэл ихсэж байгаа биш харин багасаж байгаа юм. Өгөөж нь монгол улсын эрчимтэй хөгжлийн тайван таатай нөхцөлийн баталгааг бүрдүүлж байгаад оршиж байна.

Ер нь Монгол Улсын хилийг өөрчлөх бололцоо олгохгүйгээр тухайлбал хилийн дагуу инженерийн төхөөрөмж хийх зэрэг бүх юм, тэр дотроос улсын хил хамгаалалтыг бэхжүүлэх чиглэлээр, жишээлбэл манаа харуулын байраас авахуулаад хилчдийн байлдсан, тулалдсаныг нотлох бүх юм үргүй зардалд тооцогдох ёсгүй билээ. Энэ бүхэн наагуур яривал Монгол Улсын батлан хамгаалалтыг баталгаажуулсан зайлшгүй гарах бодит зардалд хамаарагдана. Өргөн утгаар авч үзвэл улсын хил түүний орчимд хийгдэж бий болсон бүхэн Монгол Улсын тусгаар тогтнол мөнх оршиж байгаагийн баталгаа, түүний яндашгүй баялаг сан хөмрөгт оруулсан мөнхөрч үлдэх ёстой үнэт капитал юм.

*

*

*

*ХЦДС-ийн Сургалтын албаны дарга,
магистр, хурандаа М.Ахагвасүрэн*

МОНГОЛ УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦОО

Түүхийн эх сурвалжуудаас үзэхэд газар нутаг, хил хязгаарын маргаан нь дэлхийн улс үндэстнүүдийн зөрчил тэмцлийн шалтаг шалтгаан тэдгээрийн оршин тогтнох, эс оршихийг тодорхойлогч гол хүчин зүйл болсоор ирсэн.

Монгол Улсын тусгаар тогтнол хил хязгаарийн халдашгүй байдал олон зууны турш өөрчлөгдөн байсан хэдий ч устаж арилаагүйгээр барахгүй Монгол улсын төрийн хил хязгаараа баримтжуулан баталгаажуулах, хамгаалах, бэхжүүлэх талаарх бодлогын үр дүнд одоогийн хилийг тогтоож гэрээ хэлэлцээрээр